



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 12 сарын 21 өдөр

Дугаар 692

Улаанбаатар хот

“Мэдээлэл, технологийн үндэсний парк”
төрийн өмчит үйлдвэрийн газрын бүтэц, орон тооны
дээд хязгаар, албан тушаалын жагсаалт
шинэчлэн тогтоох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Мэдээлэл, технологийн үндэсний парк” төрийн өмчит үйлдвэрийн газрын зохион байгуулалтын бүтцийг дор дурдсанаар баталсугай:

- 1.1. Захиргаа удирдлагын хэлтэс
- 1.2. Мэдээллийн технологийн бизнесийг дэмжих хэлтэс
- 1.3. Хөрөнгө оруулалт, төслийн хэлтэс
- 1.4. Сургалт, судалгааны хэлтэс
- 1.5. Хэвлэл, мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс
- 1.6. Хуулийн хэлтэс

2. “Мэдээлэл, технологийн үндэсний парк” төрийн өмчит үйлдвэрийн газрын зохион байгуулалтын бүтцийн схемийг 1 дүгээр, албан тушаалын жагсаалтыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.


3. “Мэдээлэл, технологийн үндэсний парк” төрийн өмчит үйлдвэрийн газрын орон тооны хязгаарыг 43 (дөчин гурав) байхаар тогтоосугай.

4. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн “Мэдээлэл, технологийн үндэсний парк” төрийн өмчит үйлдвэрийн газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоо, албан тушаалын жагсаалт батлах тухай 89 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

5. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН
ДАРГА



Б.ЦЭНГЭЛ


Ц.БАЯР-ЭРДЭНЭ

123007073
35-r_huraldaan.docx


Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны ... дугаар сарын ...-ны өдрийн
... дугаар тогтоолын дүгээр хавсралт



**“МЭДЭЭЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ҮНДЭСНИЙ ПАРК” ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН СХЕМ**



Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2023 оны ... дугаар сарын ... -ны өдрийн
... дугаар тогтоолын 2 дугаар хавсралт



**“МЭДЭЭЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ҮНДЭСНИЙ ПАРК” ТӨРИЙН ӨМЧИГ
ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН АЛБАН ТУШААЛЫН ЖАГСААЛТ, ОРОН ТОО**

Д/д	Албан тушаал	Орон тоо
Удирдлага		
1	Захирал	1
Захиргаа, удирдлагын хэлтэс		
1	Хэлтсийн дарга	1
2	Үйл ажиллагаа хариуцсан менежер	1
3	Ерөнхий нягтлан бодогч	1
4	Нярав	1
5	Хүний нөөцийн мэргэжилтэн	1
6	Сүлжээний инженер	1
7	Бичиг хэрэг	1
8	Жолооч	1
9	Сантехникч	3
10	Цахилгаанчин	1
11	Үйлчлэгч	7
Дүн		19
Мэдээллийн технологийн бизнесийг дэмжих хэлтэс		
1	Хэлтсийн дарга	1
2	Мэдээллийн технологийн бизнес хариуцсан ахлах мэргэжилтэн	1
3	Инкубаторын менежер	1
4	Платформ хариуцсан менежер	1
5	Программ хангамжийн инженер	1
6	Инновацын бүтээгдэхүүн хариуцсан мэргэжилтэн	1
Дүн		6
Хөрөнгө оруулалт, төслийн хэлтэс		
1	Хэлтсийн дарга	1
2	Төслийн менежер	1
3	Хөрөнгө оруулалтын менежер	1
4	Гадаад харилцааны мэргэжилтэн	1
5	Мэдээллийн системийн мэргэжилтэн	1
Дүн		5
Сургалт, судалгааны хэлтэс		
1	Хэлтсийн дарга	1
2	Сургалт хөгжил хариуцсан ахлах менежер	1

3	Сургалтын менежер	1
4	Цахим ур чадвар олгох төвийн менежер	1
5	Зөвлөх багш	1
Дүн		5
Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс		
1	Хэлтсийн дарга	1
2	Маркетингийн менежер	1
3	Олон нийт цахим хөгжүүлэлт хариуцсан мэргэжилтэн	1
4	Дизайнер	1
Дүн		4
Хуулийн хэлтэс		
1	Хэлтсийн дарга	1
2	Хуулийн мэргэжилтэн	2
Дүн		3
Нийт орон тоо		43

